



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 6/168

Хэрлэн сум

Б.Баяржаргалыг ажилд
түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2, 57.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2023 оны 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгчийн албан тушаалд Баасандуламын Баяржаргалыг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс түр томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын

дарга: Б.Мөнгөнцэцэг Архивын тасгийн дарга

Гишүүд: Б.Оюунтуяа Архивын тасгийн архивын тоо бүртгэл,
сургалт сурталчилгаа хариуцсан
мэргэжилтэн

Т.Баяртуяа Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нярав

3. Б.Баяржаргалын сарын үндсэн цалинг ТҮ-6 зэрэглэлээр тогтоон, 1,003,000 (нэг сая гурван мянга) төгрөгөөр тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4. Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Б.Баяржаргалд үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНТУЛГА